

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ШУА	Шинжлэх ухааны академи
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ЗГ	Засгийн газар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	16
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	21
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	21
4. Менежментийн захидал	22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

БИОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН
ЗАХИРАЛ Я.АДЪЯА ТАНАА

2021.08.25 № 07/492
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Биологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Биологийн хүрээлэнгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгадагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно. Тайлант жилд 9 ажил гүйцэтгэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 98.2 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

- ✚ Хамаарал бүхий 1 этгээд, нэгдмэл сонирхолтой 3 этгээдтэй гэрээ хэлцэл байгуулан нийт 133,700.0 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүний худалдан авалт хийж, ажил гүйцэтгүүлсэн;
- ✚ Худалдан авалтыг цахимаар зохион байгуулаагүй 277,052.6 мянган төгрөг;
- ✚ Тус хүрээлэнгийн нэр дээр зохиогчийн эрх авсан, нэр бүхий 6 патентын эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй;

\\10.10.10.20\Bichig Khered\Yawsan Bichig\2021\0225auditin 2-R Gazar\18.Docx

001050910

✚ Холбогдох хууль, журмыг зөрчин 6,315.6 мянган төгрөгийг цалинг илүү олгосон зэрэг зөрчлүүд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, 21 дүгээр зүйлийн 21.4, УСНББОУС 31 Биет бус хөрөнгө стандартын 118 дахь заалтуудтай тус тус нийцэхгүй, Үнэн зөв байх, Үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	61,524,883.00	94,207,022.75
33	АВЛАГА	0.00	11,207,503.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	0.00	11,207,503.00
35	БАРАА МАТЕРИАЛ	61,524,883.00	82,999,519.75
35400	Хангамжийн материал	61,524,883.00	82,999,519.75
35410	Бичиг хэргийн материал	1,300,178.00	2,437,098.00
35420	Аж ахуйн материал	17,939,980.00	30,107,160.00
35430	Сэлбэг хэрэгсэл	757,000.00	1,577,800.00
35470	Бусад хангамжийн материал	41,527,725.00	48,877,461.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,076,384,231.30	2,190,747,316.90
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,076,384,231.30	2,190,747,316.90
39200	Биет хөрөнгө	1,543,327,264.62	1,896,397,480.18
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,277,082,763.09	1,277,082,763.09
39202	Хуримтлагдсан элэгдэл	(11,838,624.96)	(87,219,534.96)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	241,685,886.95	731,285,870.95
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,397,590.67)	(76,325,427.97)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	10,558,508.33	29,145,768.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	(240,283.64)	(2,690,064.86)
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,454,500.00	26,454,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,469,694.48)	(3,828,194.40)
39217	Ном	2,491,800.00	2,491,800.00
39300	Биет бус хөрөнгө	533,056,966.68	294,349,836.72
39301	Програм хангамж	1,035,650.00	1,035,650.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(69,043.32)	(276,173.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	532,090,360.00	293,590,360.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,137,909,114.30	2,284,954,339.65
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,137,909,114.30	2,284,954,339.65
51	Засгийн газрын хувь оролцоо	2,137,909,114.30	2,284,954,339.65
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,634,264,011.92	1,803,663,163.92
51200	Хуримтлагдсан үр дүн	(496,354,897.62)	(110,809,672.27)
51210	Өмнөх үеийн үр дүн	(2,511,869,148.35)	(496,354,897.62)
51220	Тайлант үеийн үр дүн	2,015,514,250.73	385,545,225.35
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		592,100,848.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,137,909,114.30	2,284,954,339.65

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,889,067,310.37	2,787,761,705.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,142,455,281.37	211,793,884.00
120	Нийтлэг татварын бус орлого	2,142,455,281.37	211,793,884.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,142,455,281.37	211,793,884.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,290,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,955,036.00	150,000.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	0.00	0.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	2,135,210,245.37	211,643,884.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	746,612,029.00	2,575,967,821.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	524,077,100.00	1,866,493,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	524,077,100.00	1,866,493,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	222,534,929.00	709,474,821.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,297,800.00	394,787,704.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	121,137,028.00	203,858,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	84,100,101.00	110,829,117.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	873,553,059.64	2,391,994,489.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	873,553,059.64	2,391,994,489.65
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	862,669,523.64	2,357,546,558.09
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	344,194,613.57	1,319,591,872.00
210101	Үндсэн цалин	245,989,013.57	992,490,415.00
210102	Нэмэгдэл	69,299,400.00	187,180,545.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	28,906,200.00	139,920,911.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,927,519.00	175,390,307.44
210201	Тэтгэврийн даатгал	26,264,027.00	123,296,894.16
210202	Тэтгэмжийн даатгал	2,892,579.00	13,210,978.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,462,544.00	10,472,801.41
210204	Ажилгүйдлийн даатгал	675,477.00	2,582,615.48
210205	Эрүүл мэндийн даатгал	6,632,892.00	25,827,017.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,390,451.00	44,578,602.00
210301	Гэрэл, цахилгаан	13,988,045.00	28,627,101.00
210302	Түлш, халаалт	3,461,678.00	13,052,745.00
210303	Цэвэр, бохир ус	940,728.00	2,898,756.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,490,439.00	42,901,135.25
210401	Бичиг хэрэг	2,165,300.00	3,100,080.00
210402	Тээвэр, шатахуун	9,600,000.00	967,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	331,400.00	1,316,189.00
210404	Ном, хэвлэл	12,709,800.00	27,054,373.25
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,073,000.00	1,022,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,610,939.00	9,440,593.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	59,140,000.00
210604	Урсгал засвар	0.00	59,140,000.00

2107	Томилолт, зочны зардал	14,882,200.00	49,840,900.00
210702	Дотоод албан томилолт	14,882,200.00	49,840,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	395,854,664.00	494,489,583.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	391,854,664.00	484,517,883.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	1,267,700.00
210807	Газрын төлбөр	4,000,000.00	6,704,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,929,637.07	171,614,158.40
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,914,400.00	16,290,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,015,237.07	155,324,158.40
2113	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,883,536.00	34,447,931.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,297,000.00	3,525,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,297,000.00	3,525,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,586,536.00	30,922,931.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,586,536.00	30,922,931.56
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	2,015,514,250.73	440,720,155.35
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	(10,221,990.00)
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	0.00	10,221,990.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	2,015,514,250.73	385,545,225.35
VI-I	Засгийн газрын хувь оролцоо	0.00	0.00
VI-II	Хяналтын бус хувь оролцоо	0.00	0.00

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	753,857,065.00	2,576,117,821.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,245,036.00	150,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,245,036.00	150,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,245,036.00	150,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,290,000.00	0.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,955,036.00	150,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	746,612,029.00	2,575,967,821.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	524,077,100.00	1,866,493,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	524,077,100.00	1,866,493,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	222,534,929.00	709,474,821.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	17,297,800.00	394,787,704.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	121,137,028.00	203,858,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	84,100,101.00	110,829,117.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	725,732,865.00	2,273,042,461.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	725,732,865.00	2,273,042,461.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	714,849,329.00	2,227,387,026.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	389,025,800.00	1,319,591,872.00
210101	Үндсэн цалин	307,188,000.00	992,490,415.00
210102	Нэмэгдэл	57,748,900.00	187,180,545.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	24,088,900.00	139,920,911.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,094,100.00	175,390,307.44
210201	Тэтгэврийн даатгал	27,302,609.00	123,296,894.16
210202	Тэтгэмжийн даатгал	6,644,800.00	13,210,978.71
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,315,800.00	10,472,801.41
210204	Ажилгүйдлийн даатгал	1,329,000.00	2,582,615.48
210205	Эрүүл мэндийн даатгал	8,501,891.00	25,827,017.68
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	21,932,200.00	44,578,602.00
210301	Гэрэл, цахилгаан	17,529,794.00	28,627,101.00
210302	Түлш, халаалт	3,461,678.00	13,052,745.00
210303	Цэвэр, бохир ус	940,728.00	2,898,756.00
2104	Хангамж, бараа материалын зардал	30,649,870.00	40,380,442.00
210401	Бичиг хэрэг	1,673,100.00	3,796,000.00
210402	Тээвэр, шатахуун	8,960,000.00	967,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	331,400.00	1,316,189.00
210404	Ном, хэвлэл	12,709,800.00	23,159,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,073,000.00	1,022,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,902,570.00	10,119,253.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	60,000,000.00
210604	Урсгал засвар	0.00	60,000,000.00
2107	Томилолт, зочны зардал	14,882,200.00	49,840,900.00
210702	Дотоод албан томилолт	14,882,200.00	49,840,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	206,350,759.00	520,794,903.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	201,386,759.00	510,590,903.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	2,000,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	964,000.00	1,500,000.00
210807	Газрын төлбөр	4,000,000.00	6,704,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,914,400.00	16,810,000.00

210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,914,400.00	16,810,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	10,883,536.00	45,655,434.56
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,297,000.00	3,525,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	5,297,000.00	3,525,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,586,536.00	42,130,434.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,586,536.00	30,922,931.56
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		11,207,503.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	28,124,200.00	303,075,360.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	28,124,200.00	303,075,360.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	28,124,200.00	303,075,360.00
2200	Дотоод эх үүсвэрээр	28,124,200.00	303,075,360.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,124,200.00	303,075,360.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(28,124,200.00)	(303,075,360.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00		0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00		(2,511,869,148.35)	(2,511,869,148.35)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00		(2,511,869,148.35)	(2,511,869,148.35)
4	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,634,264,011.92		0.00	2,634,264,011.92
5	Тайлант үеийн үр дүн	0.00		2,015,514,250.73	2,015,514,250.73
6	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,634,264,011.92		(496,354,897.62)	2,137,909,114.30
7	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,634,264,011.92		(496,354,897.62)	2,137,909,114.30
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(592,100,848.00)	592,100,848.00	0.00	0.00
9	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,042,163,163.92	592,100,848.00	(496,354,897.62)	2,137,909,114.30
10	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	(238,500,000.00)		0.00	(238,500,000.00)
11	Тайлант үеийн үр дүн	0.00		385,545,225.35	385,545,225.35
12	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,803,663,163.92	592,100,848.00	(110,809,672.27)	2,284,954,339.65

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Эхний үлдэгдэл				
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,866,493,000.00	1,835,720,068.44	30,772,931.56	98.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,866,493,000.00	1,835,720,068.44	30,772,931.56	98.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,862,968,000.00	1,832,195,068.44	30,772,931.56	98.35
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,296,085,500.00	1,279,006,557.00	17,078,943.00	98.68
210101	Үндсэн цалин	951,877,800.00	951,905,100.00	(27,300.00)	100.00
210102	Нэмэгдэл	194,150,100.00	187,180,545.90	6,969,554.10	96.41
210103	Унаа хоолны хөнгөлөлт	150,057,600.00	139,920,911.10	10,136,688.90	93.24
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	174,971,600.00	173,738,907.44	1,232,692.56	99.30
210201	Тэтгэврийн даатгал	123,128,100.00	121,645,494.16	1,482,605.84	98.80
210202	Тэтгэмжийн даатгал	12,960,900.00	13,210,978.71	(250,078.71)	101.93
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,368,700.00	10,472,801.41	(104,101.41)	101.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,592,200.00	2,582,615.48	9,584.52	99.63
210205	Эрүүл мэндийн даатгал	25,921,700.00	25,827,017.68	94,682.32	99.63
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	53,967,600.00	44,578,602.00	9,388,998.00	82.60
210301	Гэрэл, цахилгаан	27,918,700.00	28,627,101.00	(708,401.00)	102.54
210302	Түлш, халаалт	20,000,000.00	13,052,745.00	6,947,255.00	65.26
210303	Цэвэр, бохир ус	6,048,900.00	2,898,756.00	3,150,144.00	47.92
2104	Хангамж, бараа материалын зардал	37,285,500.00	35,013,202.00	2,272,298.00	93.91
210401	Бичиг хэрэг	3,750,000.00	3,750,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	967,400.00	967,000.00	400.00	99.96
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,558,000.00	2,932,402.00	625,598.00	82.42
210404	Ном, хэвлэл	24,642,200.00	22,995,900.00	1,646,300.00	93.32
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,022,900.00	1,022,900.00	0.00	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,345,000.00	3,345,000.00	0.00	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	100,000,000.00	100,000,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	40,000,000.00	40,000,000.00	0.00	100.00
210604	Урсгал засвар	60,000,000.00	60,000,000.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	27,010,900.00	27,010,900.00	0.00	100.00
210702	Дотоод албан томилолт	27,010,900.00	27,010,900.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	152,136,900.00	151,336,900.00	800,000.00	99.47
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	141,632,900.00	141,132,900.00	500,000.00	99.65
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	2,000,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	150,000.00	0.00	150,000.00	0.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	0.00	150,000.00	0.00

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210807	Газрын төлбөр	6,704,000.00	6,704,000.00	0.00	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,510,000.00	21,510,000.00	0.00	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	21,510,000.00	21,510,000.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,525,000.00	3,525,000.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,525,000.00	3,525,000.00	0.00	100.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	3,525,000.00	3,525,000.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,866,493,000.00	1,835,720,068.44	30,772,931.56	98.35
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,866,493,000.00	1,835,720,068.44	30,772,931.56	98.35
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,866,493,000.00	1,835,720,068.44	30,772,931.56	98.35
	Ажиллагсдын тоо	95	95		100.00
	Удирдах ажилтан	1	1		100.00
	Гүйцэтгэх ажилтан	82	82		100.00
	Үйлчлэх ажилтан	12	12		100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		709,474,821.00
УРСГАЛ ЗАРДАЛ		709,474,821.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		698,267,318.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		40,585,315.00
Үндсэн цалин		40,585,315.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,651,400.00
Тэтгэврийн даатгал		1,651,400.00
Хангамж, бараа материалын зардал		9,423,200.00
Бичиг хэрэг		900,000.00
Ном, хэвлэл		163,200.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		8,360,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал		208,000,000.00
Багаж, техник, хэрэгсэл		208,000,000.00
Томилолт, зочны зардал		22,830,000.00
Дотоод албан томилолт		22,830,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		415,777,403.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		415,777,403.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		11,207,503.00
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		11,207,503.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		11,207,503.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		709,474,821.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		709,474,821.00
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		394,787,704.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		203,858,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		110,829,117.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Биологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус байгууллагын Ерөнхий менежер Я.Адъяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, үндсэн хөрөнгийг стандартын дагуу бүртгэх, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, ахлах аудитор Б.Цогзолмаа, аудиторын туслах Т.Алтанчимэг, Х.Гэрэлбаяр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Биологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 01/06 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Биологийн хүрээлэн нь Монгол орны биологийн нөөц баялгийг зохистой ашиглах, хамгаалах, сэргээн үржүүлэх, биологи үндэслэл боловсруулах гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2015 оны “Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 27 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн Газар, Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Сайдын 2015 оны А/337 дугаар тушаалд ШУА-ийн Ерөнхий болон сорилын биологийн хүрээлэнгийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Монгол орны амьтны аймгийн биологи, экологи онцлог, антропогены болон уур амьсгалын өөрчлөлт амьтны аймагт нөлөөлөх зүй тогтлыг судлан илрүүлж, амьд байгалийн унаган төрх, экосистемийн тэнцвэрт байдал, биологийн олон янз байдлыг хадгалах, нөөц баялгийг хамгаалах, тогтвортой ашиглах шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулах;
2. Монгол орны амьтны гарал үүслийг тогтоох, генийн сан бүрдүүлэх, сэргээн үржүүлэх генетик үндэслэл боловсруулах, эмийн болон ганд тэсвэртэй ургамлыг биотехнологийн аргаар үржүүлэх хоёрдогч метаболитын судалгаа хийх, хавдрын эсийг дарангуйлах ургамлын гаралтай биологийн идэвхт бодисыг судлах, хавдрын молекул механизм, шалтгааныг тогтоох, оношилгооны цомог гарган авах, хувиргасан амьд организмыг илрүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Монгол улсын хууль:

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 78, 114 дугаар тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 98 дугаар тогтоолоор баталсан “Эрүүл мэндийн сургалт, эрдэм шинжилгээний зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 168 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар (covid-19)-ын цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 183 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол:

- 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай”
- 2020 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

Тус хүрээлэн нь 2020 онд суурь судалгааны чиглэлээр 5, улсын захиалгат 2, Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үйлдвэрлэл үйлчилгээнд нэвтрүүлэх чиглэлээр 2, ШУА-ийн грант төсөл 2, бусад 8 чиглэлийн төсөл арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан байна.

Үүнээс “Шинэ төрлийн коронавируст SARS-CoV2 халдварыг илрүүлэх фермент холбоот эсрэг биеийн урвалын оношлуурын цомог боловсруулах” төслийн ажил нь шинэ төрлийн коронавирусийн SARS-CoV2 омгийн вирусийн халдвар, түүний улмаас үүсэж байгаа КОВИД-19 өвчин үүсгэгчийн халдварыг хүний сийвэн, цусанд илрүүлэх SARS-CoV2 вирусийн N уурагт үндэслэсэн ЭЛИЗА оношлуурыг хийж гүйцэтгэсэн бөгөөд одоогоор оношлуурыг оюуны өмчийн баталгаажуулалт хийлгэхээр ажиллаж байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Биологийн хүрээлэнгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь БШУС-ын 2017 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Тус бодлогын баримт бичгийг салбрын хэмжээнд шинэчлэн боловсруулж 2021 оны 2 сард шинэчилсэн НБББББ-ийг мөрдөхөөр болсон байна.

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны эхний хагас жилийн санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,123,944.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22,478.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,413,423.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 24,134.2 мянган төгрөгөөр тооцлоо. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хувь хэмжээг бууруулсан нь эрсдэл их гэж тооцсонтой холбоотой болно.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Биологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 147,045.2 мянган төгрөгөөр буюу 6.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, биет бус хөрөнгө, өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага		11,207.5	11,207.5
Бараа материал	61,524.9	82,999.5	21,474.6
Үндсэн хөрөнгө	2,076,384.2	2,190,747.3	114,363.1
Нийт хөрөнгө	2,137,909.1	2,284,954.3	147,045.2
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,137,909.1	2,284,954.3	147,045.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,137,909.1	2,284,954.3	147,045.2

Авлага дансны үлдэгдэл 11,207.5 мянган төгрөг болж 11,207.5 мянган төгрөгөөр өссөн нь нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулаагүй үлдэгдлийн төвлөрүүлэх шилжүүлгийг буцаан авахаар авлагаар бүртгэснээс шалтгаалжээ. Авлага дансны үлдэгдэлд насжилт өндөртэй болон тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 82,999.5 мянган төгрөг болж 21,474.6 мянган төгрөгөөр өссөн нь түүх соёлын дурсгал зүйлээр бүртгэгдэх амьтны чихмэлүүдийг бараа материалаар бүртгэснээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд насжилт өндөртэй, ашиглалтгүй, нөөц үүсгэн худалдан авсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,190,747.3 мянган төгрөг болж 114,363.1 мянган төгрөгөөр өссөн нь элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосноос шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал санхүүжилтээр 95,075.4 мянга, нэмэлт санхүүжилтээр 208,000.0 мянга, Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 13,891.6 мянга, ТӨБЗГ-ын 401 тоот тогтоолоор үнийг шинэчлэн тогтоосон 187,530.3 мянга, бараа материалаас үндсэн хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэн 3,690.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

ТӨБЗГ-ын газрын 2020 оны 391 дүгээр тогтоол, А-1/1132 тоот албан бичгээр 44,952.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталсан байна.

ТӨБЗГ-ын 2020 оны 512 дугаар тогтоолоор 238,500.0 мянган төгрөгийн газар эзэмших эрхийг данснаас хасаж, балансаас балансад шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,284,954.3 мянга болж 147,045.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 385,545.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, данснаас хассан газар эзэмших эрхэд хамаарах 238,500.0 мянган төгрөгөөр төрийн өмчийг бууруулснаас шалтгаалжээ.

Биологийн хүрээлэнгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 56,352.7 мянган төгрөгөөр буюу 1.9 хувиар буурсан байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үнэ төлбөргүй хүлээн авсан орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилт, нэмэлт санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 1,573,616.4 мянган төгрөгөөр буюу 180.1 хувиар өсөж бүх зардлын дансанд материаллаг өөрчлөлт гарсан.

Эдгээр нь тус хүрээлэн ЗГ-ын 2019 оны 328 дугаар тогтоолоор Ботаникийн цэцэрлэгт хүрээлэнгийн бүтэц зохион байгуулалттай хамт 158 орон тоотой байсныг Биологийн хүрээлэн нэртэйгээр тусдаа 95 орон тоотой шинээр байгуулагдсантай холбоотойгоор 2019 оны санхүүгийн тайланд 9 сараас 12 сар дуусталх хугацааны орлого зардал тусгагдсан тул орлого болон зардлын бүх дансуудад материаллаг өөрчлөлт гарсан болно.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд бүтэц зохион байгуулалтын өөрчлөлт хийгдэхээс өмнөх байдлаар тооцон зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,774,155.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 3,774,155.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс бүтэц зохион байгуулалтын өөрчлөлттэй холбоотойгоор 1,907,662.8 мянган төгрөгөөр бууруулж 1,866,493.0 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,866,493.0 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,866,493.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,835,720.1 мянган төгрөгийг зарцуулж, дутуу зарцуулсан 30,772.9 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,835,720.1 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 18,311.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 9,388.9 мянга, хангамж, бараа материалын зардлыг 2,272.3 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 800.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 30,772.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71808	Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	1,866,493.0	1,835,720.4	(30,772.9)	98.4
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,862,968.0	1,832,195.1	(30,772.9)	98.3
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	3,525.0	3,525.0		100

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хандив тусламжаар 394,787.7 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 203,858.0 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 110,829.1 мянга, нийт 709,474.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин нийгмийн даатгалын зардалд 42,236.7 мянга, хангамж, бараа материалын зардалд 9,423.2 мянга, эд хогшил худалдан авах зардалд 208,000.0 мянга, томилолт, зочны зардалд 22,830.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 415,777.4 мянга, нийт 698,267.3 мянган төгрөгийг зарцуулж, дутуу зарцуулсан 11,207.5 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 188 мэдээллээс хугацаандаа оруулсан 3 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 3 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналтай тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 13 удаагийн 559,749.1 мянга, худалдан авалтын 4 удаагийн 77,970.0 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд байршуулаагүй;
- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 109 удаагийн гүйлгээгээр 1,049,273.6 мянган төгрөгийг шилэн дансанд байршуулахдаа холбогдох шийдвэрийг байршуулаагүй;
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 18 харилцагчтай холбоотой 426,950.2 мянган төгрөгийн гэрээний мэдээлэл болон хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг байршуулаагүй,
- Худалдан авалт, тендерийн сонгон шалгаруулалт зарлагдсан боловч шилэн дансанд тухайн мэдээллийг оруулаагүй “байхгүй” гэж оруулсан;

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн санхүүгийн программд шинэчлэлт сайжруулалт хийх зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	-	1	-	-	-	-
Нийт дүн	1	-	1	-	-	-	-

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,330,811.1 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 648,261.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 7,565.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 490,493.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 184,491.3 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн байдлын тайланд тусгагдсан засгийн газрын хувь оролцооны дүн нь өмчийн өөрчлөлтийн тайланд тусгагдсан засгийн газрын хувь оролцооны дүнгээс 11,207.5 мянган төгрөгөөр илүү илэрхийлэгдэж, тооцооллын алдаа гаргасан;
2. Барилга байгууламжид хамаарах 592,100.8 мянган төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг засгийн газрын оруулсан капиталгаар бүртгэсэн;
3. Бүтцийн өөрчлөлтөөр үндсэн хөрөнгийг бүртгэхдээ элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгүүдийг бүртгэлд тусгаагүй. Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 44,952.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг ТӨБЗГ-ын шийдвэрээр актлахдаа тэдгээр хөрөнгүүд нь бүртгэлгүй байсан тул үнэ төлбөргүй хүлээн авсан орлого болон үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз дансыг нэмэгдүүлэн буруу тайлагнасан зэрэг алдаа, зөрчлийг аудитын явцад залруулсан.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 682,549.9 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 7,565.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 490,493.0 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Ур чадварын нэмэгдлийг олгох тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн 1 ажилтанд 1,250.0 мянга, батлагдсан орон тоонд тусгагдаагүй албан тушаалыг хавсран ажилласан нэмэгдлийг 2 ажилтанд 6,315.6 мянган төгрөгийг тус тус илүү олгосон нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 “Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ” 16.5.3 “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Хамаарал бүхий 1 этгээд, нэгдмэл сонирхолтой 3 этгээдтэй гэрээ хэлцэл байгуулан нийт 133,700.0 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүний худалдан авалт хийж,

ажил гүйцэтгүүлсэн нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” 11.2-д “Албан тушаалтан өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй ашгийн төлөө үйл ажиллагаатай харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн этгээдтэй холбогдох захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно” гэж заасантай нийцэхгүй, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Худалдан авалтыг цахимаар зохион байгуулаагүй 277,052.6 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалт хийсэн, тендерийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй, тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй оролцогчийг сонгон шалгаруулж 79,740.8 мянган төгрөгийн худалдан авалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2 “Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ” 33.2.1 “үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх”, 21 дүгээр зүйлийн 21.4 “Захиалагч тендерийн урилгыг энэ хуулийн 52.1.12-т заасан цахим хуудсанд байрлуулж тендер шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлнэ”, 49 дүгээр зүйлийн 49.2 “Тендерийн хавтаст хэрэг дараах баримт бичиг, материалаас бүрдэнэ” гэж заасантай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Шинэ бүтээл ашиглуулах лицензийн гэрээний дагуу хүрээлэнгийн нэгдмэл сонирхолтой этгээд болох Алтан биопласт ХХК-д хүрээлэнгийн өөрийн ажлын байрны Б корпуст судалгаа шинжилгээний ажил, оюуны өмчийн шинэ бүтээл гаргах зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмжийн хамт төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр үнэ төлбөргүй ашиглуулж байна. Мөн тус хүрээлэнгийн нэр дээр зохиогчийн эрх авсан, нэр бүхий 6 патентын эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1 “Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессын болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно”, УСНББОУС 31 Биет бус хөрөнгө стандартын 118 “Биет бус хөрөнгийн анги гэдэг нь байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдах байдлын хувьд ижил төсөөтэй шинж төрөл ба хэрэглээ бүхий хөрөнгүүдийн бүлэг юм. Үүнд: (д) Зохиогчийн эрх, патент гэж заасныг тус тус мөрдөөгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

5. Шилэн дансанд 3 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 13 удаагийн 559,749.1 мянган төгрөг, үүнээс худалдан авалтын 4 удаагийн 77,970.0 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд дутуу байршуулсан, 109 удаагийн гүйлгээгээр 1,049,273.6 мянган төгрөгийг шилэн дансанд байршуулахдаа холбогдох шийдвэрийг байршуулаагүй, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 18 харилцагчтай холбоотой 426,950.2 мянган төгрөгийн гэрээний мэдээлэл болон хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг огт байршуулаагүй, мөн худалдан авалт, тендерийн сонгон шалгаруулалт зарлагдсан боловч шилэн дансанд “байхгүй” гэж оруулсан нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д “Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална” 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх” 4.1.2 “мэдээлэл

ойлгомжтой, ач холбогдолтой байх” 4.1.3-д “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 184,491.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Хүрээлэн нь жил бүр төсөл хөтөлбөр хэрэгжүүлэн нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлэн зарцуулдаг. Тус орлогыг гэрээнд заасан зориулалтын дагуу үнэн зөв зарцуулсан эсэх, түүнийг холбогдох журмын дагуу нягтлан бодох бүртгэлд тайлагнасан эсэх, төслийн үр дүн ач холбогдолтой эсэх нь анхаарал татахуйц байгаа тул дараагийн аудитаар авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

Тус хүрээлэн нь тээврийн хэрэгсэлгүй тул албан томилолтоор хөдөө орон нутаг явахдаа машин түрээсэлдэг, үүнтэй холбоотой тайлант онд 58,223.0 мянган төгрөгийг тээврийн зардалд зарцуулсан. Үүнээс 19,303.0 мянган төгрөгийг 4 төрийн бус байгууллагад шилжүүлсэн байгаа нь анхаарал татсан болно. Мөн жил бүр тээврийн зардалд зарцуулах дүн нь тээврийн хэрэгсэл худалдан авах зардлаас их байх магадлалтай эсэхийг судалж төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулах, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Өмнөх аудит болон зөвлөмжийн биелэлт, үр дүнтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайлангийн эхний үлдэгдэлд үндсэн хөрөнгө болон хуримтлагдсан үр дүнг өмнөх аудитаар баталгаажсан үлдэгдлээс 4,650.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, тус дүнгээр Э-тайланд баталгаажсан;

1.2. Эрсдэл:

Эхний үлдэгдэл өмнөх аудитын тайлангаар баталгаажсан үлдэгдлээс зөрүүтэй илэрхийлэгдэх;

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална” 5.1.4-т “үнэн зөв байх” гэж заасны дагуу хөрөнгө данснаас хасахдаа холбогдох тушаал, шийдвэрийг үндэслэн тухайн тайлант оны бүртгэлд тусгаж, аудитад хүргүүлж байх;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Бүтцийн өөрчлөлт хийгдсэнтэй холбоотой тухайн тайлант онд зайлшгүй тус хөрөнгийн хөдөлгөөнийг хийх шаардлага үүссэн тул өмнөх аудитын тайлангаас зөрүүтэй тайлагнагдсан. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллана.

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүн нь улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан дүрмийн сангийн хэмжээнээс 238,500.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнагдсан;

2.2. Эрсдэл:

Засгийн газрын оруулсан капитал зөрүүтэй илэрхийлэгдэх, холбогдох журмыг зөрчих;

2.3. Өгсөн зөвлөмж:

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 8.2 “Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ” 8.2.3 “хувь нийлүүлсэн хөрөнгө” заалтын дагуу улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Тайлант онд газар эзэмших эрхийг балансаас балансад шилжүүлсэнтэй холбоотой ба цаг хугацааны хувьд цар тахлын онцгой дэглэмийн нөхцөл байдал таарсан тул 2021 оны нэгдүгээр улиралд багтаан залруулна.

3.Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Тайлант онд 135 харилцагчтай холбоотой 898,595.8 мянган төгрөгийн гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 40 харилцагчтай холбоотой 148,086.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй;

3.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээг бүртгэлд тусгах;

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Татварын цахим бүртгэлд зарим аж ахуйн нэгж байгууллага төлбөрийн баримт шивсэн боловч буцаах, худалдан авалт хийх явцад зах зээлийн үнээс бага үнээр худалдсан НӨАТ төлөхгүй гэх тайлбар өгч төлбөрийн баримт шивээгүй байна. Цаашид төлбөрийн баримтыг бүрэн гаргуулан авч ажиллана.

4. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн хураамжийн ангиллаас цалин хөлсний зардалд 10,980.1 мянган төгрөгийг зарцуулсан.

4.2. Эрсдэл:

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг буруу ангилан тайлагнасан байх;

4.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан "Эдийн засгийн ангилал батлах тухай заавар"-ын дагуу төсвийн зардлын ангиллыг үнэн зөв ангилж тайлагнах;

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид батлагдсан төсөв, гэрээний дагуу зохих зардлын ангилалд бүртгэх болно.

5.Балансын данстай холбоотой асуудал

5.1. Илрүүлэлт:

Түүх соёлын дурсгалт зүйлд хамаарах 6 нэр төрлийн 20,775.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн, тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилд ашиглагдах амьтны чихмэлийг хэрхэн бүртгэх талаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй, хэрхэн бүртгэгдэх нь тодорхойгүй байна;

5.2. Эрсдэл:

Эргэлтийн бус хөрөнгө болон эргэлтийн хөрөнгийг буруу ангилан бүртгэх;

5.3. Өгсөн зөвлөмж:

Соёлын өвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 “Дараах соёлын биет өвийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйлд хамааруулна” 6.1.4 “ховор болон ховордсон ургамлын хатаамал цуглуулга, амьтны чихмэл” гэсэн заалтын дагуу түүх соёлын дурсгалт зүйлээр эргэлтийн бус хөрөнгөд бүртгэгдэхээр байгааг судалж үзээд бүртгэлд хэрхэн тусгах талаар Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусган, мөрдөж ажиллах;

5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Цаашид төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар болон холбогдох байгууллагад албан бичгээр хүсэлт хүргүүлэн дээрх хөрөнгийг үнэлэх бүртгэлд хэрхэн тусгах ажлыг зохион байгуулна;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Биологийн хүрээлэнгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит			Аудитын код:
2021.02.19					САГ-2021/118/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Биологийн хүрээлэн			Мянган төгрөг
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Шинэ бүтээл ашиглуулах лицензийн гэрээний дагуу хүрээлэнгийн нэгдмэл сонирхолтой этгээд болох Алтан биопласт ХХК-д хүрээлэнгийн өөрийн ажлын байрны Б корпуст судалгаа шинжилгээний ажил, оюуны өмчийн шинэ бүтээл гаргах зорилгоор шаардлагатай тоног төхөөрөмжийн хамт төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр үнэ төлбөргүй ашиглуулж байна. Тайлант онд шинээр авсан 2 зохиогчийн эрх, 1 патент эзэмшигчийн гэрчилгээ болон өмнө нь гаргуулан авсан бүх патент болон зохиогчийн эрхийг санхүүгийн тайланд биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй.		Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
2	Эхний үлдэгдэлд үндсэн хөрөнгө болон хуримтлагдсан үр дүнг өмнөх аудитаар баталгаажсан үлдэгдлээс 4,650.2 мянган төгрөгөөр дутуу тайлагнаж, тус дүнгээр Э тайланд баталгаажсан.	4,650.2	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
3	Хамаарал бүхий 1 этгээд, нэгдмэл сонирхолтой 3 этгээдтэй гэрээ хэлцэл байгуулан 133,700.0 мянган төгрөг олгосон.	133,700.0	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
4	Санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүн нь улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан дүрмийн сангийн хэмжээнээс 238,500.0 мянган төгрөгөөр дутуу тусгагдсан.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
5	Шилэн дансанд 15 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг байршуулаагүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 13 удаагийн 559,749.1 мянган төгрөг, үүнээс худалдан авалтын 4 удаагийн 77,970.0 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд дутуу		Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн

	байршуулсан, 109 удаагийн гүйлгээгээр 1,049,273.6 мянган төгрөгийг шилэн дансанд байршуулахдаа холбогдох шийдвэрийг байршуулаагүй, Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 18 харилцагчтай холбоотой 426,950.2 мянган төгрөгийн гэрээний мэдээлэл болон хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг огт байршуулаагүй, мөн худалдан авалт, тендерийн сонгон шалгаруулалт зарлагдсан боловч шилэн дансанд байхгүй гэж оруулсан байна.				
6	Мөнгөн хөрөнгийн гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 40 харилцагчтай холбоотой 148,086.0 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй байна.	148,086.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн хураамжийн ангилалд цалин хөлс 10,980.1 мянган мянган төгрөгийн зардлыг буруу хуваарилан бүртгэсэн байна.	10,980.1	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
8	Эргэлтийн бус хөрөнгийн түүх соёлын дурсгалт зүйлд хамаарах 6 нэр төрлийн 20,775.0 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн	20,775.0	Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
9	Ур чадварын нэмэгдлийг олгох тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн 1 ажилтанд 1,250.0 мянган төгрөг, батлагдсан орон тоонд тусгагдаагүй албан тушаалыг хавсран ажилласан нэмэгдлийг 2 ажилтанд 6,315.6 мянган төгрөгийг илүү олгосон.	7,565.6	Төлбөрийн акт тогтоох	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
10	Харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах 2 төрлийн 82,297.5 мянган төгрөг, нээлттэй тендер шалгаруулалтаар сонгон шалгаруулах 2 төрлийн 194,755.1 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим системд байршуулаагүй шууд гэрээ байгуулсан, 2 төрлийн 79,740.8 мянган төгрөгийн худалдан авалтыг харьцуулалтын аргаар сонгон шалгаруулахдаа тендерийн баримт бичгийн бүрдэл хангалтгүй, тендерийн баримт бичигт заасан шаардлагыг хангаагүй оролцогчийг сонгон шалгаруулсан.	356,793.0	Албан шаардлага өгөх	Захирал Нягтлан бодогч	Я.Адъяа Ё.Гангамөрөн
ДҮН		682,549.9			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АКТ

2021 оны 02 дугаар сарын 25 № 14/АД160958
САГ-2021/118 /СТА-ТМЗ
Төлбөр барагдуулах тухай

Улаанбаатар хот

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Биологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Ур чадварын нэмэгдэл олгох тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн 1 ажилтанд 1,250.0 мянган төгрөг, батлагдсан орон тоонд тусгагдаагүй албан тушаалыг хавсран ажилласан нэмэгдлийг 2 ажилтанд 6,315.6 мянган төгрөгийг тус тус илүү олгосон.

Энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 3-т "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д "Төсвийн шууд захирагч нь төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ" 16.5.3-т "батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин хөлсийг тогтоох", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-т заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Биологийн хүрээлэнгийн ажилтан, албан хаагчдад илүү олгосон 7,565.6 мянган төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлж, Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Биологийн хүрээлэнгийн захирал Я.Адъяа, нягтлан бодогч Ё.Гангамөрөн нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ
Б.СЭРЖМЯДАГ
Т.ОДОНЧИМЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Akt\2021\0225auditin 2-R Gazar 15.Docx

001090432



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 44/АДМ0058

Улаанбаатар хот

САГ- 2021/118/СТА-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Биологийн хүрээлэнгийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хамаарал бүхий 1 этгээд, нэгдмэл сонирхолтой 3 этгээдтэй гэрээ хэлцэл байгуулан нийт 133,700.0 мянган төгрөгийн бараа бүтээгдэхүүний худалдан авалт хийж, ажил гүйцэтгүүлсэн, мөн 277,052.6 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авах сонгон шалгаруулалтыг цахимаар зарлаагүй, нэгдмэл сонирхолтой хуулийн этгээдэд төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын зөвшөөрөлгүйгээр ажлын байрыг үнэ төлбөргүй ашиглуулсан, тус хүрээлэнгийн эзэмшлийн 6 патентын эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй, шилэн дансанд 4 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, 1 мэдээллийг байршуулаагүй, 559,749.1 мянган төгрөгийн 13 удаагийн гүйлгээний мэдээлэл, 1,049,273.6 мянган төгрөгийн 109 гүйлгээнд холбогдох шийдвэр, 18 харилцагчтай холбоотой 426,950.2 мянган төгрөгийн гэрээний мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1-д "Албан тушаалтан албан үүргээ гүйцэтгэхдээ өөрийн болон өөртэй нь хамаарал бүхий этгээдийн хувийн ашиг сонирхлыг хөндсөн захиргааны шийдвэр гаргах, удирдах, хяналт, шалгалт хийх, хариуцлага хүлээлгэх, гэрээ байгуулах, эдгээрийг хэлэлцэх, бэлтгэх, оролцох зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-т "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д "Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр концессын болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр 4.1.1-т "мэдээлэл

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardlaga\2021\0225auditin 2-R Газар30.Docx

001081119

үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Биологийн хүрээлэнгийн захирал Я.Адъяа, нягтлан бодогч Ё.Гангамөрөн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Т.ОДОНЧИМЭГ

[illegible]

This image shows a full page of white paper with horizontal dotted lines. The lines are evenly spaced and run across the width of the page, providing a guide for handwriting practice. There are no margins, text, or other markings on the page.